



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

---

### Нийцлийн аудитын тайлан

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн



СУМДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ,  
СУРАЛЦАГЧДЫН ТЭТГЭЛЭГЭЭС 26,595.8 МЯНГАН ТӨГРӨГИЙГ ЗОРИУЛАЛТ  
БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2016 он

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p><b>Говьсүмбэр аймгийн<br/>аудитын газар</b></p> <p><b>Тэргүүлэх аудитор<br/>Ш.Ичинхорлоо</b></p> <p><b>Аудитын менежер<br/>Б.Сарантуяа</b></p> <p><b>Ахлах аудитор<br/>Ц.Батсайхан</b></p> <p><b>Аудитор<br/>Г.Наранбаяр</b></p> <p><b>2016 оны 10 дугаар сар</b><br/>Аудитын тайлан,<br/>дүгнэлттэй холбоотой<br/>асуудлаар нэмж<br/>тодруулах, асууж лавлах<br/>зүйл байвал 7054-3151<br/>дугаарын утас, 7054-<br/>3179 дугаарын факсаар<br/>харилцана уу<br/><b>ХАЯГ:</b></p> <p><b>Аймгийн Засаг даргын<br/>тамгын газрын байр, 2<br/>давхар, 217 тоот</b></p> | <p>Товчилсон үгийн тайлбар .....4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5</p> <p><b>БҮЛЭГ 1: Хууль эрх зүйн үндэслэлгүйгээр сангийн дансыг төсвийн байгууллагын үйл ажиллагааны данстай нэгтгэж тайлагнасан байна.</b></p> <p>1.1 Говьсүмбэр аймагт Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүй зөрчигдсөн байна.</p> <p>1.2 Хууль эрх зүйн үндэслэлгүйгээр Байгаль хамгаалах сангийн дансыг хааж, төсвийн байгууллагын үйл ажиллагааны данстай нэгтгэж тайлагнасан байна.</p> <p>1.3 Байгаль хамгаалах сангийн тусгай данс байхгүйгээс 2015-2016 онд тус нөхөн төлбөрийн орлого 8,324.5 мянган төгрөгийн БОАЖГ-ын үйл ажиллагааны зардлын дансанд төвлөрүүлсэн байна.</p> <p><b>БҮЛЭГ 2: Сумдад Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг төлөвлөж батлаагүйгээс байгаль орчны асуудал орхигдсон байна.</b></p> <p>2.1 Сумдад Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг төлөвлөж батлуулаагүй байна.</p> <p>2.2 Сумдын БХС-д нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлсэн байна.</p> <p><b>БҮЛЭГ 3: Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байна.</b></p> <p>3.1 Сүмбэр сумын Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг сумын ИТХ-ын тогтоол, шийдвэргүйгээр зарцуулсан, зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.</p> <p>3.2 Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Төсөл хөтөлбөрийг шууд гэрээгээр гүйцэтгүүлж, гэрээний биелэлтийг дүгнэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.</p> <p><b>БҮЛЭГ 4: Дотоод хяналтын тогтолцоог журмын дагуу бүрдүүлээгүй, сумдад сангийн хөрөнгөд тавих дотоод хяналт байхгүй байна.</b></p> <p>4.1 Дотоод хяналтын тогтолцоог холбогдох журмын дагуу бүрдүүлээгүй байна.</p> <p>4.2 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу Шивээговь, Баянтал сумын БХС-ийн мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлээгүй байна.</p> <p>Дүгнэлт.....</p> <p>Зөвлөмж.....</p> <p>Холбогдох байгууллагын санал:.....</p> <p>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал .....</p> <p>Саналд өгсөн тайлбар .....</p> <p>Хавсралтууд</p> |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

## Товчилсон үгийн тайлбар

[illegible]

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

**Аудитын зорилт:** Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиудын хүрээнд “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан”, “Байгаль хамгаалах сангуудын үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

**Аудитын хамарсан хүрээ:** Аудитад аймгийн БОАЖГ-ын БОХНСАХ-ний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын байгаль хамгаалах сан болон Политехник коллежийн 2015 он, 2016 оны 09-р сар хүртэлх үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримт материалууд болон холбогдох бусад баримтуудыг хамрууллаа.

**Аудитын арга зүй:** Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын гарын АДБОУС 4000-4200, Санхүүгийн тайлангийн аудитаас ангид гүйцэтгэх нийцлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах зэрэг сорил, горимуудыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлж, үнэлэх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. /Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №2, 3-аас үзнэ үү/

### **Үндсэн мэдээлэл**

#### **“Байгаль хамгаалах сан”**

Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор “Байгаль хамгаалах сан”-г анх байгуулж, 2012 оны 189 дүгээр тогтоолоор “Байгаль хамгаалах сан”-гийн журам болон зохион байгуулалт, орон тооны хязгаарыг, “Сангийн удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар тус тус баталсан байна.

МУ-ын Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 4/1-416 тоот албан бичгийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар баталсан төсвийн байгууллагад хамаарахгүй боловч төсвийн байгууллагын нэг адил төрийн санд данс нээж санхүүжүүлж байгаа зарим хөтөлбөр, арга хэмжээний шинжтэй зүйлсээр нээсэн данснуудыг цэгцлэх ажил хийгдэж, аймгийн Байгаль хамгаалах санг, Байгаль орчны аялал жуучлалын газарт нэгтгэж байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал нэрээр тусгасан байна.

Гэтэл МУ-ын Засгийн газрын Байгаль хамгаалах санг татан буулгах, Байгаль орчин, аялал жуучлалын газрын байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал нэрээр үйл ажиллагааны зардалд нэгтгэх, мөн өмнөх тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгосон зэрэг тогтоол шийдвэр гараагүй байхад зөвхөн Сангийн

сайд албан тоот гаргаж, аймаг орон нутгийн байгаль хамгаалах санг татан буулгасан байна.

Харин аймгийн сумдын байгаль хамгаалах сангууд татан буугдаагүй ба уг сангуудад байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний орлогыг төвлөрүүлж, зарцуулалтыг хийж, үйл ажиллагаа явуулж байна.

2015 оны Байгаль хамгаалах сангийн эхний үлдэгдэл Сүмбэр суманд 3,290.9 мянга, Шивээговь суманд 1,701.0 мянга, Баянтал суманд 1,441.7 мянга, нийт 6,433.6 мянган төгрөг байсан бол тайлант онд сумдын Байгаль хамгаалах санд нийт 27,258.9 мянган орлогыг төвлөрүүлж, оны эцэст 31,842.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тухайлбал: Тайлант онд Сүмбэр сум 25,458.9 мянга, Баянтал сум 1,800.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж, Сүмбэр сум 1,850.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст Сүмбэр сум 26,899.8 мянга, Баянтал 3,241.7 мянга, Шивээговь сум 1,701.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2016 оны Байгаль хамгаалах сангийн эхний үлдэгдэл Сүмбэр суманд 26,899.8 мянга, Шивээговь суманд 1,701.0 мянга, Баянтал суманд 3,241.7 мянга, нийт 31,842.5 мянган төгрөг байсан ба тайлант оны эхний хагас жилд Сүмбэр сум 600.0 мянга, Шивээговь сум 1,000.0 мянга, нийт 1,600.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, Сүмбэр сум 6,462.3 мянган төгрөгийг зарцуулж, эхний хагас жилийн байдлаар Сүмбэр сум 26,980.2 мянга, Бянтал сум 3,241.7 мянга, Шивээговь сум 2,701.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### **“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”**

“Мэргэжлийн боловсрол сургалтын тухай” хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санг байгуулж Засгийн газрын 2011 оны 117 тоот тогтоолоор “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд заасны дагуу уг сангийн санхүүгийн удирдлагын үүргийг Хөдөлмөрийн сайд эрхлэх бөгөөд сангийн хөрөнгийн зарцуулалтад боловсрол, санхүү, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл хяналт тавин ажиллаж байна.

Говьсүмбэр аймагт тус Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан байхгүй ба аймгийн Политехник коллежийн суралцагчдын тэтгэлгийг БСШУЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас олгосон байна. Политехник коллежийн суралцагчдын тэтгэлэгт 2015 онд 141,131.4 мянга, 2016 онд 133,307.5 мянган төгрөгийг тус тус олгосон байна

## Бүлэг 1

**Хууль эрх зүйн үндэслэлгүйгээр сангийн дансыг төсвийн байгууллагын үйл ажиллагааны данстай нэгтгэж тайлагнасан байна.**

### **1.1 Говьсүмбэр аймагт Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүй зөрчигдсөн байна.**

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулах дараах хууль эрх зүйн орчин Говьсүмбэр аймагт бүрдээгүй байна . Үүнд:

1. Засгийн газрын тусгай сангийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2, 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасан тусгай сангийн төрөл, ангилалын дагуу сумдын Байгаль хамгаалах сангууд үйл ажиллагаагаа явуулж байна. Харин аймгийн Байгаль хамгаалах санг Сангийн сайдын ирүүлсэн албан тоотын дагуу татан буулгасан байна.
2. Засгийн газрын тусгай сангийн хуулийн 12 дугаар зүйлд тусгасан Байгаль хамгаалах сангийн эх үүсвэр болон зарцуулах арга хэмжээний зардлыг СС-аас ирүүлсэн албан тоотын дагуу аймгийн ИТХ төвлөрүүлэх орлогыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр, зардлыг БОАЖГ-ын БОХНСАХ-ний зардал нэрээр үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхээр баталсан байна.
3. Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах сан”-гийн журам,
4. Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 43-р тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”

Дээрх 2 журам нь Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 4/1-416 тоот албан бичгээр ирүүлсэн шийдвэрийн дагуу орон нутагт хэрэгжихгүй байна.

Тус аймагт Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан байхгүй болно.

### **1.2 Хууль эрх зүйн үндэслэлгүйгээр Байгаль хамгаалах сангийн дансыг хааж, төсвийн байгууллагын үйл ажиллагааны данстай нэгтгэж тайлагнасан байна.**

Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын тусгай сангийн хууль болон бусад холбогдох журмын хүрээнд бие даан үйл ажиллагаагаа явуулахаар байгаа боловч тус аймагт Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 4/1-416 тоот албан бичгээр ирүүлсэн шийдвэрийн дагуу төсвийн байгууллагад хамаарахгүй боловч төсвийн байгууллагын нэг адил төрийн санд данс нээж санхүүжүүлж байгаа зарим хөтөлбөр, арга хэмжээний шинжтэй зүйлсээр нээсэн данснуудыг цэгцлэх ажлын хүрээнд аймгийн байгаль хамгаалах санг татан буулгаж, аймгийн төрийн санд байрших байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны дансыг нь хааж, орлогыг нь орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж, зардлыг нь БОАЖГ-ын БОХНСАХ-ний зардал нэрээр үйл ажиллагааны зардалд нэгтгэж төсвийг нь баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор баталсан журмын хавсралтын 1.2-д “Байгаль хамгаалах сан нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, бэлэгдэл, хэвлэмэл хуудас хэрэглэнэ”, “Сан нь Төрийн санд харилцах данстай байна” гэснийг тус тус зөрчиж байна.

Иймд Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэргүйгээр Сангийн сайдын албан тоотоор аймаг орон нутгийн байгаль хамгаалах санг татан буулгасан асуудлыг харьяалах дээд шатны байгууллагад тавьж улсын хэмжээнд шийдвэрлүүлэх саналыг Нийцлийн аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

**1.3 Байгаль хамгаалах сангийн тусгай данс байхгүйгээс 2015-2016 онд тус нөхөн төлбөрийн орлого 8,324.5 мянган төгрөгийн БОАЖГ-ын үйл ажиллагааны зардлын дансанд төвлөрүүлсэн байна.**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль хамгаалах санд оруулна” гэж заасан боловч Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д уг нөхөн төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын талаар тодорхой тусгаж өгөөгүй байна.

Дээрх Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” 2-ын зөрүүтэй байдлаас шалтгаалан нөхөн төлбөрийн орлогыг ямар байгууллагын ямар дансанд төвлөрүүлэх, мөн уг орлогыг ямар үйл ажиллагаанд зарцуулах нь тодорхойгүй байна.

2015-2016 онд аймгийн БХС-д төвлөрүүлвэл зохих нөхөн төлбөрийн 8,324.5 мянган төгрөгийн орлогыг БОАЖГ-ын үйл ажиллагааны дансанд төвлөрүүлсэн бөгөөд уг орлогыг зарцуулах тухай тодорхой эрх зүйн акт байхгүйгээс зарцуулагдаагүй ба 2015 оны 2,819.5 мянган төгрөгийг оны төгсгөлд орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн бол 2016 он 5,505.0 мянган төгрөгийн орлого нь зарцуулагдаагүй БОАЖГ-ын дансанд үлдэгдэлтэй байна.

Тус аймагт Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан орлогууд орох боломжгүй хэдий ч зардал гаргаж, арга хэмжээг зохион байгуулах, хуулийн хэрэгжилтыг хангаж ажиллах шаардлагатай байдгаас шалтгаалан БОХНСАХ –ний зардлыг зориулалт бусаар зарцуулах эрсдэлтэй байна.

Тухайлбал: Аймгийн хэмжээнд БОХНСАХ-ний зардлыг санхүүжүүлэх гол эх үүсвэр нь зөвхөн Усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд журамд заасны дагуу Усны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулахаар байгаа хэдий ч байгаль орчны чиглэлээр хийгдэх бусад ажлууд орхигдох хүндрэл бэрхшээлтэй байдаг тул уг журмыг орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэчлэн боловсруулах, өөрчлөлт оруулах шаардлагатай байна

## Бүлэг 2

### Сумдад Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг төлөвлөж батлаагүйгээс байгаль орчны асуудал орхигдсон байна.

#### 2.1 Сумдад Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг төлөвлөж батлуулаагүй байна.

Аймгийн Байгаль хамгаалах сан татан буугдсан тул байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогуудыг аймгийн төсвийн орлогын дансанд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг аймгийн төвд БОХНСАХ-ний зардал нэрээр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсөвт нэгтгэн төлөвлөж, батлуулсан байна.

Харин Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад Байгаль хамгаалах сан нь тусгай данстай үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг зарцуулна” гэсний дагуу сумдын Байгаль хамгаалах сангийн орлогыг 2015-2016 онд төлөвлөж батлуулаагүй байна.

Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйл “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэснийг зөрчсөн байна.

Сүмбэр сумын Засаг даргын 2016.09.06-ны өдрийн А/113 тоот захирамжаар 2016 онд Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг баталсан боловч. Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн орлогын эх үүсвэр, зарцуулалт, хийгдэх ажлын жагсаалтыг хууль журамд заасны дагуу сумын ИТХ-аар батлуулаагүй байна.

Мөн Сүмбэр сум нь байгаль хамгаалах сангийн орлогын эх үүсвэрийг төлөвлөж батлуулаагүй боловч тус сангийн өмнөх оны зарцуулаагүй үлдэгдлийг сумын ИТХ-аар тодотгол хийлгэлгүй шууд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Сумдын Байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төсөв, хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг батлаагүйгээс сумдад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хэрэгжүүлэх ажлууд орхигдсон байна.

Мөн сумдын байгаль орчны байцаагч нарын тогтвор сууршилгүй байдлаас ажил хариуцсан ажилтнууд удаа дараа өөрчлөгдсөнөөс шалтгаалан сумдад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон энэ чиглэлээр хийгдэх ажлууд туйлын хангалтгүй байна.

Аудитын явцад шаардлагатай ажлын тайлан, мэдээ, судалгаа, гэрээ хэлцэлийг ирүүлэхгүй өмнөх ажилтан хүлээлгэж өгөөгүй, байхгүй, мэдэхгүй гэсэн хандлагаар хандаж байгаа нь тухайн ажилтны ажлын хариуцлага сул байгаагаас



гадна сумдын ЗДТГ, Засаг дарга нар ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулж, ажлын тайлан, үр дүнгийн гэрээг бодитой дүгнэж ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд Байгаль хамгаалах сангийн тухайн тайлант жилийн орлого, зарлагыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу бодит тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, ажлын явц, биелэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

## 2.2 Сумдын БХС-д нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлсэн байна.

Сумдын Байгаль хамгаалах санд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заагдаагүй орлогууд, мөн байгалийн нөөцийн хайгуулийн болон ашиглалтын лицензтэй компаниудын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг байршуулсан байна.

Сумдын байгаль хамгаалах санд 2015 онд 27,258.9 мянга, 2016 онд 1,600.0 мянга, нийт 28,858.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

2015-2016 онд сумдын Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн орлогын судалгааг дараахь хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

| Огноо    | Сумдын нэр | Байгаль хамгаалах сангийн орлого |                    |              |                                   | Нийт дүн |
|----------|------------|----------------------------------|--------------------|--------------|-----------------------------------|----------|
|          |            | Агнуурын орлого                  | Зөвшөөрлийн орлого | Хогны орлого | Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө |          |
| 2016     | Сүмбэр     |                                  |                    |              | 600.0                             | 600.0    |
|          | Баянтал    |                                  |                    |              |                                   | 0.0      |
|          | Шивээговь  |                                  |                    |              | 1,000.0                           | 1,000.0  |
| Нийт дүн |            | 0.0                              | 0.0                | 0.0          | 1,600.0                           | 1,600.0  |
| 2015     | Сүмбэр     | 24,852.9                         | 100.0              | 6.0          | 500.0                             | 25,458.9 |
|          | Баянтал    |                                  |                    |              | 1,800.0                           | 1,800.0  |
|          | Шивээговь  |                                  |                    |              |                                   | 0.0      |
| Нийт дүн |            | 24,852.9                         | 100.0              | 6.0          | 2,300.0                           | 27,258.9 |

Хүснэгтээс харахад: 2015 онд тус сангийн орлогын 91,17 хувь буюу 24.852.9 мянган төгрөг нь ан, агнуурын, 0.37 хувь буюу 100.0 мянган төгрөг нь зөвшөөрлийн, 8.44 хувь буюу 2.300.0 мянган төгрөг нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн, 0,02 хувь буюу 6,0 мянган төгрөг нь хогны орлогоос тус тус бүрдсэн байна.

Хогны орлого нь Татварын тухай хуульд зааснаар орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрөх орлого бөгөөд данс андууран тус санд төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг төлбөр, хураамжийг үндэслэн 2015 онд Сүмбэр суманд 2 угалз агнах зөвшөөрөл олгож, агнуулсан байна. Тогтоолын дагуу Сүмбэр сумын байгаль хамгаалах санд 2 угалзын төлбөр 14,000 доллар, аймгийн орон нутгийн төсөвт хураамжийн орлого 4,000 долларыг тус тус төвлөрүүлсэн боловч Аудитын явцад Угалз агнах зөвшөөрөл олгосон шийдвэр, ан агнуурын гэрээ, хэлцэлийг авч тулган баталгаажуулах гэсэн боловч байгуулсан гэрээ алга болсон шалтгаанаар ирүүлээгүй болно.

Ан, агнуурын төлбөрийн 24,852.9 мянган төгрөгийн орлогыг Сүмбэр сумын Байгаль хамгаалах санд, хураамжийн 10,999.5 мянган төгрөгийн орлогыг сумын орон нутгийн төсвийн орлогын дансанд тус тус төвлөрүүлсэн байна.

Дээрх орлогуудаас гадна хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж, байгууллагаас Байгаль хамгаалах санд 2015 онд 2,300.0 мянга, 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 1,600.0 мянга, нийт 3,900.0 мянган төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг байршуулсан байна.

Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйлийн 9.10-т “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Иймд байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг хууль журамд заасны дагуу орлого болон зардлын төрөл тус бүрээр үнэн бодит тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж батлуулж байх, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг тусгай дансанд байршуулан зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмжүүдийг өгөхөөр шийдвэрлэв.

Тус аймагт Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан байдаггүй учраас Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас Аймгийн Политехник коллежийн нэмэлт санхүүжилтийн дансанд суралцагчдын тэтгэлэгт 2015 оны 1 дүгээр улирлаас 3 дугаар улиралыг дуустал 141,131.4 мянга, 2016 оны 1 дүгээр сард 2015 оны 4 дүгээр улиралд төгссөн суралцагчдад олгох тэтгэлэгт 12,971.7 мянга, нийт 154,103.1 мянган төгрөгийн санхүүжилтийг шилжүүлж, суралцагчдын тэтгэлгийг олгосон байна.

МУ-ын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 477 дугаар тогтоолоор “Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг олгох тухай журам”-д оруулсан өөрчлөлтийн дагуу 2016 оны 01 дүгээр сараас суралцагчдад олгодог тэтгэлгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас шууд суралцагчийн картан дансанд шилжүүлдэг болсон байна.

Мэргэжлийн боловсролыг дэмжих сан нь 2016 оны 1 дүгээр сараас 6 сарыг дуустал “Капитал” банкны Говьсүмбэр аймаг дахь салбараар дамжуулан Политехник коллежийн суралцагчдад 120,335.8 мянган төгрөгийн тэтгэлгийг олгосон байна. Үүнд: 2016 оны 1,2 дугаар сарын тэтгэлэгт 35,944.4 мянга, 2015 оны 4 дүгээр улирлын үлдэгдэл тэтгэлэгт 84,391.4 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж үр дүн гарч байна үү

## Бүлэг 3

Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул  
байна

### **3.1 Сүмбэр сумын Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг сумын ИТХ-ын тогтоол, шийдвэргүйгээр зарцуулсан, зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.**

2015-2016 оны 3 дугаар улирлын байдлаар Шивээговь, Баянтал сумын Байгаль хамгаалах сангаас зарлагын гүйлгээ гараагүй байна.

Сүмбэр сумын Байгаль хамгаалах сангаас 2015-2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 11,312.3 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд аудитын явцад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- 2015 онд Байгаль хамгаалах үйл ажиллагааны шатахууны зардалд 1,850.0 мянган төгрөг зарцуулсанаас 150.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг Засаг даргын захирамжгүй, хийсэн ажлын тайлан, шатахуун зарцуулалтын тооцоо болон жолоочийн тооцооны хуудасгүй, 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 2,092.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан гэх боловч хийсэн ажлын тайлан, шатахуун зарцуулалтын тооцоо, жолоочийн тооцооны хуудасгүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Иймд 3,342.3 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын анхан шатны баримт, тооцоонуудыг бүрдүүлж, гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж ирүүлэх тухай хугацаатай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

- 2016 оны 2 дугаар сард Сүмбэр сумын 5 дугаар багийн нутаг тусгай хамгаалалттай Чойр ууланд хяналтын байр буюу Боржигон байшин барих ажлыг 5,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр иргэн И.Лхагважавтай гэрээ байгуулсан байна. Уг гэрээний техникийн тодорхойлолтод сумын нутагт дэвгэрээс 35 км-т тээвэрлэн угсрах ажлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцахаар заасан боловч Сүмбэр сумын Засаг даргын 2016 оны А/89 тоот захирамжаар Боржигон байшинг хүргэх, угсрах байршуулахад шаардагдах шатахууны зардалд 600.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Иймд давхардуулан олгосон шатахууны зардлыг холбогдох эзнээр буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар нийт 24,686.8 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрсэн бөгөөд үүний 3,342.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч, 600.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, орон нутгийн орлого болгохоор шийдвэрлэв

### **3.2 Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Төсөл хөтөлбөрийг шууд гэрээгээр гүйцэтгүүлж, гэрээний биелэлтийг дүгнэлгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.**

2016 онд Сүмбэр сумын БХС-аас Боржигон байшин барих, Шар бүрдний эхийг хамгаалах” ажлуудыг төсөвт өртөг бага тул шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Үүний 2016 оны 02-р сард Боржигон байшин барих ажлыг 5,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн боловч санхүүжилтийг 520.0 мянган төгрөгөөр дутуу олгосон, ажил хүлээлцсэн болон гэрээг дүгнэсэн баримтгүй байна.

2016 онд иргэн Б.Мэнд-Амартай гэрээ байгуулан “Шар бүрдний эхийг хамгаалах” ажлыг 3,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон боловч ажил хүлээлцсэн болон гэрээг дүгнэсэн баримтгүй байна.

Иймд ажлын хэсэг томилон ажлыг хүлээн авч, гэрээг дүгнэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Политехник коллежийн суралцагчдын тэтгэлэг олголтын талаар:

2015 онд Аймгийн Политехник коллеж нь нийт 519 суралцагчдад 238,494.3 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоос 2015 оны 1-3 дугаар улирлыг дуустал 141,131.2 мянган төгрөгийг олгож, 97.363.1 мянган төгрөгийн тэтгэлгийг олгоогүй байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар 2015 оны 4 дүгээр улирлын суралцагчдын олгогдоогүй тэтгэлэг 97,363.1 мянга, 2016 оны 1-2 улиралд нийт 416 суралцагчдад олговол зохих тэтгэлэг 120,924.1 мянга, нийт 218,287.2 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоос 133,307.5 мянган төгрөгийн тэтгэлгийг олгож, суралцагчдын 3-6 сарын 84,979.7 мянган төгрөгийн тэтгэлэгийг олгоогүй байна.

Аудитын явцад суралцагчдын тэтгэлэг олголттой холбоотой дараахь зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус коллеж нь суралцагчдын 2015 оны 1, 2 дугаар сарын тэтгэлэг 46,027.4 мянган төгрөгийг 2015.04.10-ны өдрийн 02 тоот төлбөрийн хүсэлтээр Хас банкны Говьсүмбэр аймаг дахь салбарын 5001075709 тоот дансанд шилжүүлсэн байна. Гэтэл Хас банк суралцагчдын дансанд 35,347.4 мянган төгрөгийг шилжүүлж, 10,679.9 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.

Дээрх дутуу шилжүүлсэн 10,679.9 мянган төгрөгийг тус коллежийн Захирлын 2015.04.08-ны 01/90 тоот албан бичгийн дагуу доорх байгууллагуудад шилжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн Музейн 220035010 тоот дансанд үзвэрийн үнэ 199.5 мянга,
  - Боржигин чуулгын 220035012 тоот дансанд тоглолтын үнэ 800.0 мянга,
  - “Жигүүр катеринг” ХХК-ны Төрийн банкны 109500055642 тоот дансанд сургуулийн дотуур байрны хаалганы үнэ 7,210.4 мянга,
  - Улирал ба зохиолч сэтгүүл газрын Голомт банкны 102000042936 тоот дансанд номын үнэ 825.0 мянга,
  - “Хөх монгол принтинг” ХХК-ны төрийн банкны 1410005545 тоот дансанд номын үнэ 160.0 мянга
  - “Нерко” ХХК-ны Голомт банкны 1102893206 тоот дансанд номын үнэ 1,485.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.
- Суралцагчдын 2015 оны 03, 04, 05 дугаар саруудын тэтгэлэг 56,557.7 мянган төгрөгийг 2015.06.23-ний өдрийн 02 тоот төлбөрийн хүсэлтээр Хас банкны Говьсүмбэр аймаг дахь салбарын 5001075709 тоот дансанд шилжүүлсэн боловч Хас банк нь суралцагчдын дансанд 49,481.8 мянган төгрөгийн тэтгэлэгийг шилжүүлж, 7,075.9 мянган төгрөгийн тэтгэлгийг дутуу шилжүүлсэн байна.

Хас банк нь дээрх дутуу шилжүүлсэн 7,075.9 мянган төгрөгийн тэтгэлэгийг тус коллежийн Захиргаа аж ахуйн албаны даргын гарын үсэг бүхий 2015.03.23-ний өдрийн дугааргүй албан тоотын дагуу Пүрэв овогтой Мөнхцоожийн Хас банкны 5000357141 тоот дансанд шилжүүлсэн байна. Уг тэтгэлгийн мөнгийг дор дурьдсан төлбөрт суутган авч үлдсэн байна. Үүнд:

-  Номны үнэ, тоглолтын үнэнд суралцагч бүрийн тэтгэлгээс 17.0 мянган төгрөгөөр тооцон, нийт 6,384.4 мянга,
  -  Дотуур байранд амьдардаг суралцагчдын тэтгэлгээс хагарсан цонхны үнэнд 691.5 мянган төгрөгийг тус тус суутган шилжүүлсэн байна.
- Суралцагчдын 2015 оны 09 дүгээр сарын тэтгэлэг 35,218.9 мянган төгрөгийг 2015.12.04-ний өдрийн 02 тоот төлбөрийн хүсэлтээр Хас банкны Говьсүмбэр аймаг дахь салбарын 5001075709 тоот дансанд шилжүүлсэн боловч Хас банк нь 26,378.9 мянган төгрөгийн тэтгэлэгийг суралцагчдын дансанд шилжүүлж, 8,840.0 мянган төгрөгийн тэтгэлгийг шилжүүлээгүй байна.

Хас банк нь дээрх дутуу шилжүүлсэн 8,840.0 мянган төгрөгийг тус коллежийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн гарын үсэг бүхий 2015.11.15-ний өдрийн дугааргүй албан тоотын дагуу Пүрэв овогтой Мөнхцоожийн Хас банкны 5000094151 тоот харилцах дансанд шилжүүлсэн байна. Уг тэтгэлгийг дор дурдсан төлбөрт суутган авсан байна. Үүнд:

-  номны үнэ,
-  Боржгон чуулгын тоглолтын үнэнд суралцагч бүрийн тэтгэлгээс 17.0 мянган төгрөгөөр тооцон суутган авч шилжүүлсэн байна.

Энэ нь суралцагчдын гарын үсэг бүхий зөвшөөрөл, сургуулийн эрх бүхий албан тушаалтаны шийдвэргүй, хүчин төгөлдөр бус хуурамч бичиг баримт бүрдүүлэн суралцагчдын тэтгэлгийг зориулалт бусаар зарцуулж, Засгийн газрын тусгай сангийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д “Төрийн сангийн газар нь Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно”, 32 дугаар зүйлийн 32.1-д “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”, Засгийн газрын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3-д “Сургууль нь суралцагчдын тэтгэлгийг сар бүрийн 3 дахь долоо хоногт бэлэн бусаар олгоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Засгийн газрын 2015 оны 477 тогтоолоо баталсан “Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- 2015 онд Суралцагчдын тэтгэлгийн олгогдоогүй үлдэгдэл 97,363.1 мянга, 2016 оны эхний хагас жилд суралцагчдын тэтгэлгийн олгогдоогүй үлдэгдэл 84,979.1 мянга, нийт 182,342.2 мянган төгрөгийн тооцооны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Иймд Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сантай тооцоо нийлж, суралцагчдын тэтгэлгийн үлдэгдлийг баталгаажуулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

## Бүлэг 4

Дотоод хяналтын тогтолцоог журмын дагуу бүрдүүлээгүй, сумдад сангийн хөрөнгөд тавих дотоод хяналт байхгүй байна.

### 4.1 Дотоод хяналтын тогтолцоог холбогдох журмын дагуу бүрдүүлээгүй байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/02 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар “Байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлын журам”-ыг баталж, Дотоод хяналт шалгалтыг хариуцсан ажилтныг томилон ажиллуулсан байна.

Харин сумдын Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, тогтолцоо бүрдээгүй ба сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга буюу төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нарын зүгээс хэрэгжүүлэх хяналт хангалтгүй байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан байгууллагын дотоод ажлын төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалт хийж, ажлын тайланг Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж ажилласан байна. Дотооддоо зохион байгуулсан хяналт шалгалтанд аймгийн байгаль хамгаалах орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл хамрагдсан ба сумдын байгаль хамгаалах санд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас олгож буй тэтгэлгийн санхүүжилт, зарцуулалтанд Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дотоод хяналт болон Коллежийн удирдлагаас хэрэгжүүлэх хяналт хангалтгүй байна.

Иймд аймгийн болон сумдын Байгаль хамгаалах болон мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог холбогдох хууль эрхийн хүрээнд зохион байгуулан ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### 4.2 Шилэн дансны тухай хуульд заасны дагуу Шивээговь, Баянтал сумын БХС-ийн мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлээгүй байна.

Шилэн дансны нэгдсэн цэсэнд аймгийн Байгаль орчны газарт БОХНСАХ-ний зардал нэрээр, Сүмбэр сум сумын байгаль хамгаалах сан нэрээр батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, таван сая төгрөгнөөс дээш мэдээллийг байршуулж мэдээлсэн байна. Харин Шивээговь, Баянтал сумдууд Байгаль хамгаалах сангийн мэдээллийг цэс нээж нэгдсэн шилэн данс цэсэнд байршуулаагүй байна.

Иймд Шивээговь, Баянтал сумдын байгаль хамгаалах сангийн төсвийг баталж, шилэн дансны нэгдсэн цэсэнд мэдээллийг байршуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.



## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

### Зорилт 1 хүрээнд:

- Тус аймагт Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 4/1-416 тоот албан бичгээр ирүүлсэн шийдвэрийн дагуу төсвийн байгууллагад хамаарахгүй боловч төсвийн байгууллагын нэг адил төрийн санд данс нээж санхүүжүүлж байгаа зарим хөтөлбөр, арга хэмжээний шинжтэй зүйлсээр нээсэн данснуудыг цэгцлэх ажлын хүрээнд аймгийн байгаль хамгаалах санг татан буулгаж, аймгийн төрийн санд байрших байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны дансыг нь хааж, орлогыг нь орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлж, зардлыг нь БОАЖГ-ын БОХНСАХ-ний зардал нэрээр үйл ажиллагааны зардалд нэгтгэж төсвийг нь баталсан,
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” 2-ын зөрүүтэй байдлаас шалтгаалан 2015-2016 онд аймгийн БХС-д төвлөрүүлвэл зохих нөхөн төлбөрийн 8,324.5 мянган төгрөгийн орлогыг БОАЖГ-ын үйл ажиллагааны дансанд төвлөрүүлсэн бөгөөд уг орлогыг зарцуулах тухай тодорхой эрх зүйн акт байхгүйгээс зарцуулагдаагүй ба 2015 оны 2,819.5 мянган төгрөгийг оны төгсгөлд орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн бол 2016 он 5,505.0 мянган төгрөгийн орлого нь зарцуулагдаагүй БОАЖГ-ын дансанд үлдэгдэлтэй байна.

### Зорилт 2 хүрээнд

- Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад Байгаль хамгаалах сан нь тусгай данстай үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг зарцуулна” гэсний дагуу сумдын Байгаль хамгаалах сангийн орлогыг 2015-2016 онд төлөвлөж батлуулаагүй байна.
- Аймгийн Политехник коллежийн суралцагчдын 2016 оны 3-6 сарын 84,979.7 мянган төгрөгийн тэтгэлгийг олгоогүй байна.

### Зорилт 3 хүрээнд

- Сүмбэр сумын Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг сумын ИТХ-ын тогтоол, шийдвэргүйгээр зарцуулсан, зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл

хангалтгүй, БХС-ийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн ажлыг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

- Политехник коллеж нь суралцагчдын гарын үсэг бүхий зөвшөөрөл, сургуулийн эрх бүхий албан тушаалтаны шийдвэргүй, хүчин төгөлдөр бус хуурамч бичиг

баримт бүрдүүлэн суралцагчдын тэтгэлгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

- Политехник коллеж нь суралцагчдын 2015-2016 оны тэтгэлгийн олгогдоогүй үлдэгдэлийг МБСДС-тай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

#### **Зорилт 4 хүрээнд**

- Сумдын Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, тогтолцоо бүрдээгүй ба сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга буюу төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нарын зүгээс хэрэгжүүлэх хяналт хангалтгүй,
- Шивээговь, Баянтал сумдууд Байгаль хамгаалах сангийн мэдээллийг цэс нээж нэгдсэн шилэн данс цэсэнд байршуулаагүй байна.



## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

### **Аймгийн Байгаль орчны газрын дарга Д.Мөнх-Эрдэнэд**

1. Аймгийн БОХНСАХ-ний зардлыг аймгийн байгаль хамгаалах санд төвлөрүүлвэл зохих орлогыг бүрэн төвлөрүүлж, зориулалтыг дагуу зарцуулах,
2. БОХНСАХ-ний зардлаар хийгдэж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр олгохгүй байх,
3. Төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлын гэрээний биелэлтийг дүгнэж байх, уг хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгийг ажлын хэсэг байгуулан хүлээн авч бүртгэл тайланд тусгах,
4. Аймаг болон сумдын Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог холбогдох хууль эрхийн хүрээнд зохион байгуулан ажиллах, сумдын байгаль орчны асуудал хариуцсан ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах

### **Сумдын Засаг дарга нарт:**

1. Байгаль орчны улсын байцаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэх
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” –д заасан орлогыг нэр төрлийн дагуу төвлөрүүлэх, зардлыг зориулалтын дагуу үнэн зөв төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйлийн 9.10-д зааснаар төвлөрч байгаа барьцаа хөрөнгийг тусгай данс нээж төвлөрүүлэх,
5. Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах,
6. Шивээговь, Баянтал сум байгаль хамгаалах сангийн үйл ажиллганы ил тод байдлыг хангаж, нэгдсэн шилэн данс цэсэнд байршуулах,
7. Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх
8. Нийцлийн аудитаар тогтоогдсон акт, албан шаардлагыг хугацаанд нь барагдуулж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

### **Аймгийн Политехник коллежийн захирал С.Ууганбаатарт**

1. Суралцагчдын тэтгэлэгийн олгогдоогүй үлдэгдлийг МБСДС-тай тооцоо нийлж, батлагаажуулж байх.
2. Суралцагчдын тэтгэлэгийг бодож олгохдоо ирцийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах.

## ҮАГ-ЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

### Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт уламжлах санал

- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэргүйгээр Сангийн сайдын албан тоотоор аймаг орон нутгийн байгаль хамгаалах санг татан буулгасан асуудлыг харьяалах дээд шатны байгууллагад тавьж улсын хэмжээнд шийдвэрлүүлэх.
- Тус аймагт Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасан орлогууд орох боломжгүй хэдий ч зардал гаргаж, арга хэмжээг зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байдгаас шалтгаалан БОХНСАХ-ний зардлыг зориулалт бусаар зарцуулах эрсдэлтэй байна.

Тухайлбал: аймгийн хэмжээнд БОХНСАХ-ний зардлыг санхүүжүүлэх гол эх үүсвэр нь зөвхөн Усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд журамд заасны дагуу Усны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулахаар байгаа хэдий ч байгаль орчны чиглэлээр хийгдэх бусад ажлууд орхигдох хүндрэл бэрхшээлтэй байдаг тул уг журмыг орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэчлэн боловсруулах, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.